

## АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ-НИЙГМИЙН БАЙДЛЫН 2013 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

**Мал онд оролт:** Нэгдүгээр улирлын байдлаар мал сүрээг 99.2 хувиар онд орж, бүгд 16.1 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар бага байна. Нийт хорогдлын 64.1 хувийг Жаргалан, Тонхил, Халиун, Есөнбулаг сумдын хорогдсон мал эзэлж байна.

**Төл бойжилт:** Аймгийн дүнгээр 274.6 мянган толгой буюу төллөх хээлтэгчийн 35.1 хувь төллөж, 271.9 мянган төл 99.0 хувиар бойжиж байна. Төгрөг, Хөхморьт, Чандмань, Шарга сумд гарсан төлөө 100.0 хувиар бойжуулжээ.

**Аймгийн Хөдөө аж ахуй жижиг дүнд үйлдвэрийн газар:** Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас зохион байгуулан хэрэгжүүлж буй сумдын мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтнүүдийг мал ангилалтын багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд “Хас цахим эрдэнэ тамга” ХХК -аас тус аймагт нийлүүлсэн малын жин (1 тонн) 20 ширхэг, малын жин (60 кг) 20 ширхэг, палкметр, лентметр, ареометр тус бүр 40 ширхэг, үхрийн ээмэг 9921 ширхэг, ээмэглэгч бахь 7 ширхэг, бар код уншигч 1 ширхэг, мал ангилалтын хашаа 1 ширхэг зэрэг 9 нэр төрлийн нийт 44.1 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч сумдад олгох ажлыг зохион байгуулсан байна.

Бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад инженерийн хийцтэй 20 худаг шинээр гаргахаар тендер зарлажээ.

Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх боловсруулалтын арга хэмжээнд 23.7 мал, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 40.1 мянган мал хамрагдсан байна. Лабораторийн шинжилгээг нийтдээ 62 дээжинд шинжилгээ хийлээ. Ариутгал халдваргүйжүүлэлтийг 7350 м<sup>2</sup> талбайд хийсэн байна. МЭАЦ-ийн шинжилгээнд арьс шир 2040 ширхэг, сүү, сүүн бүтээгдэхүүн 720 литр, мах 35100 тонныг хамруулан шинжилжээ.

**Үнэ:** Малчдын орлогын зонхилох хувийг бүрдүүлдэг ямааны ноолуурын үнэ түүвэр судалгаанд хамрагдсан Алтай хотод дараах байдалтай байв.

Сарууд	I	II	III
1 кг ноолуурын үнэ /мянган төгрөг/	48.0	48.0	48.0

Аймгийн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс түүвэр судалгаанд хамрагдсан Алтай хотод 3 дугаар сарын 21-ний байдлаар суурь он болох 2010 оноос 26.1, энэ оны хоёрдугаар сараас 1.4 хувиар тус тус өссөн байна.

**Аж үйлдвэр:** Тайлант хугацаанд Алтай-Улиастай, Мандал голомт, Тулга-Алтай, Гоби гоулд, Ентүм, Ундрам оюу, Шимт дээж, Ундарга-Алтай, Баярт-Олон, Удмын-Ундраа, зэрэг 33 аж ахуйн нэгж, 105 хувиараа хөдөлмөр эрхлэгч үйлдвэрлэл явууллаа. Аймгийн дүнгээр энэ салбарт 3 тэрбум 540.5 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2 тэрбум 382.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлууллаа. Гол нэрийн бүтээгдэхүүнээс сувагжуулалт, нүүрс, архи дарс, түгээсэн ус өнгөрсөн оны мөн үеэс 0.9 - 34.1 хувиар, монгол дээл, зайрмаг үйлвэрлэл 3.6 - 40.0 дахин нэмэгдлээ. Харин цахилгаан, дулаан, гутал, ботинк, хиам амтат ундаа, талх, нарийн боов үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 1.3-61.1 хувиар буурчээ.

**Төсвийн орлого:** Орон нутгийн төсөвт 928.6 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 88.3 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 190.0 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 145.2 хувиар биелүүлж, аймгийн төсвийн нийт орлого 99.6 хувиар биелэв.

**Төсвийн зарлага:** Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтын 84.8 хувь буюу найман тэрбум 879.0 сая төгрөгөөр санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшлын төлөвлөгөөний 89.1, нийгмийн даатгалын шимтгэлийн 87.4, бараа үйлчилгээ бусад зардлын 63.6 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

**Төсвийн өглөг:** Аймгийн дүнгээр 74.8 сая төгрөгийн өглөгтэй байгаагийн 44.8 хувь нь цалин, 15.4 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, 19,2 хувь нь түлш халаалт, 20.6 хувь нь бусад зардлын өр эзэлж байна.**Төсвийн авлага:** Төсөвт байгууллагуудад 13.3 сая төгрөгийн авлага байгаа ба 100.0 хувь бусад зардлын авлага байна. Дээрхи авлагын 91.9 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээ, 8.0 хувийг боловсролын салбар эзэлж байна.

**Банкны мөнгөн орлого, зарлага:** Бүгд 4 тэрбум 312.8 сая төгрөгийн зузаатгал хийж кассын гүйлгээнээс 66 тэрбум 440.2 сая төгрөг татаж, монгол банкинд 4 тэрбум 934.2 сая төгрөг шилжүүлж, гүйлгээнд 64 тэрбум 396.8 сая төгрөг гаргалаа. Зээлийн өрийн бүх үлдэгдэл 47 тэрбум 416.1 сая төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 0.4 хувийг эзэлж байна. Иргэдийн хадгаламж өнгөрсөн оны энэ үеэс 24.2 хувиар өсч, хугацаат хадгаламж 60.2 хувийг эзэлж байна.

**Эрүүл мэнд:** Энэ улиралд 350 эх амаржиж 356 хүүхэд эсэн мэнд төрлөө. Одоогоор аймгийн хэмжээнд эмнэлгийн хяналтанд хамрагдсан 705 жирэмсэн эхчүүд байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 12 тохиолдол бүртгээгдсэн байна. Бүртгээгдсэн 69 халдварт өвчний өвчлөл дотроос гепатит, гахайн хавдар тус бүр 8.7 хувийг, бэлгийн замын халдварт өвчнүүд 52.1 хувийг, бусад өвчлөл 30.5 хувийг эзэлж байна. Энэ улиралд хорт хавдараар шинээр өвчилсөн 30, мөн өвчнөөр нас барсан 21, амиа хорлосон болон зам тээврийн ослоор тус бүр 2, бусад ослоор нас барсан 3 тохиолдол бүртгээгдлээ. Тайлант онд эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүд нийт 64.1 мянган хүнд үзлэг хийж, 4.0 мянган хүнийг хэвтүүлэн эмчилж, 31.5 мянган ор хоног ашигласан байна. Эхний улиралд 10.3 мянган хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан 4.6 мянган хүнийг идэвхитэй хяналтанд авч үйлчилжээ. Мөн 5.2 мянган удаа түргэн тусламжийн дуудлагад үйлчилсний 0.8 мянган нь алсын дуудлагад гарч үйлчилжээ.

**Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс:** Хүүхдийн дууны “Дуулах өв-2013”, “Өвлөн бүжигцгээе” ардын бүжгийн наадам, уран уншлагын “Уран жиргээ-2013” наадмыг зохион байгуулж нийт 352 хүүхэд оролцон авьяас чадвараа сорилоо. 8-11-р ангийн 150 охидод “Дотно яриа” чин сэтгэлийн ярилцлага хийж санал бодлоо солилцсон байна. Дүдү боловсрол сангийн тэргүүн Д.Мөнхтулгыг урьж тус хэлтсийн мэргэжилтнүүд “Ангийн дарга нарыг чадваржуулах”, “Бидний манлайлал”, “Нийгмийн ажилтнуудыг чадваржуулах”, байгууллагын ажилтнуудад шинэ мэдээ мэдээлэл өгөх сургалтыг зохион байгууллаа. “Цэвэр агаар” сэдэвт явган аялалыг зохион байгуулж 68 хүүхэд оролцлоо.

**“Дэлхийн Зөн Монгол” ОУБайгууллага:** Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хөдөөний иргэдийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулж, 4 хүнийг сургагч багшаар бэлтгэжээ. Сангийн яамтай хамтарч төсвийн шинэ хуулиар 7.5 сая төгрөгийн санхүүжилтээр 2010 хүнд сургалт зохион байгуулсан.

**Аймгийн Аудитын газар:** 2013 оны 1улиралд Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор , мөн хуулийн 15.2-т заасан бүрэн эрхийн дагуу Төсвийн тухай хуулинд заасан төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагчдын 2012 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нийт 203 байгууллагын санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийхээр төлөвлөж гэрээний дагуу аудит хийж байна . Аудитад хамрагдсан байгууллагуудын урьдчилсан дүнгээр аудитаар 10561.3 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж, 3207.6 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад барагдуулж, орон нутгийн төсвийн орлогод оруулахаар 349.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогоод байна. Аудитаар илэрсэн зөрчлөөс хамааран 36 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар томилдог эрх бүхий байгууллагын удирдлагад санал хүргүүлжээ. Аудитаас 1137.8 сая төгрөгийн үр өгөөж бүртгээд байна.

**Байгаль орчин, аялал жуулчлалын газар:** Ард иргэд, эко клуб, идэвхтэн байгаль хамгаалагчид, байгаль орчны салбарын ажилтнуудад зориулсан сургалт, сурталчилгааны ажлуудыг түлхүү зохион байгууллаа. Жил бүрийн 3 сарын 22-ны өдөр буюу Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, уг ажлын хүрээнд мэргэжилтнүүд болон оюутан, сурагчид нийт 300 гаруй хүүхэд залууст усыг хайрлан хамгаалах, зүй зохистой ашиглах талаар “Ус чандмань эрдэнэ” сэдэвт мэдээллийг хийсэн. “Эх дэлхийн цаг” хөтөлбөрийн хүрээнд айл өрх, албан байгууллага, болон нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгүүдийг нэг цаг унтраан, Алтай хотын төв талбайд цугларч лаа барьж бүх нийтээрээ идэвхтэй оролцлоо.

**Мэргэжлийн хяналтын газар:** Бүгд 254 байгууллага, 156 салбар нэгж, 2422 хүнийг хамарсан мэргэжлийн хяналт хийж, 865 зөрчил илрүүлсний 59.8 хувийг газар дээр нь арилгуулав. Байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн зөрчилтэй үйл ажиллагааг засахад чиглэгдсэн 2393.6 мянган төгрөгийн торгууль тавьж барагдуулалт 100 хувьтай байна. Мөн гаргасан актын 90.0 хувь, албан шаардлагын 35.2 хувийг биелүүлээд байна. Бүгд 5 байгууллагын санхүүгийн баримтанд шалгалт хийж 24.5 сая төгрөгийн акт тавьсны 37.2 хувийг барагдуулсан байна.

**Нийгмийн даатгалын хэлтэс:** Нийгмийн даатгалын шимтгэлээр нэг тэрбум 253.1 сая төгрөг, тэтгэврийн санхүүжилтээр нэг тэрбум 900.0 сая төгрөг, бүгд гурван тэрбум 153.1 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрүүлж, нийт 6.0 мянган хүнд олговол зохих гурван тэрбум 438.3 сая төгрөгийг бүрэн олголоо. Тэтгэмжийн даатгалаар олговол зохих 140.5 сая төгрөг, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын 9.9 сая төгрөгийг тус тус бүрэн олгожээ. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр өмнөх улирлынхаас 1.4 дахин нэмэгдсэн байна.

**Хөдөлмөрийн хэлтэс:** Улирлын эцсийн байдлаар хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн ажилгүйчүүд өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өсч 790 болсны дотор 63.0 хувь буюу 498 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн 276 нь дээд, 57 нь тусгай дунд, 254 нь бүрэн дунд, 97 нь бүрэн бус дунд, 42 нь мэргэжлийн анхан шатны, 54 нь бага, 10 нь ямарч боловсролгүй хүмүүс байна.

**Халамж үйлчилгээний хэлтэс:** Ажилгүйдлийн тэтгэмжийг 50 хүнд 52.0 сая төгрөг олгож, мэргэжлийн сургалтанд 84 хүн хамруулж 11.4 сая төгрөгийг зарцуулжээ. Мөн ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх хөнгөлөлт, жирэмсэн болон амаржсан, хүүхэд асарсан, хүүхэд үрчилж авч өсгөсөн, ихэр ба өнчин хүүхэд өсгөсөн, хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэл насны хүүхэд, насанд хүрэгчдэд олгох халамж, байнгын асаргаа шаардлагатай иргэн, ахмад настны хөнгөлөлт, тусламж нийт 4.3 мянган хүнд 882.9 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгосон байна. Мөн алдарт эхийн одонтой 4.1 мянган ээжид 646.0 сая төгрөг, алдар цолтой 25 ахмадад 13.2 сая төгрөгийг тус тус олгожээ.

**Биеийн тамир спортын хороо:** Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах чөлөөт, самбо бөх, шатрын тэмцээнд нийт 34 хүүхэд оролцон 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн байна. Оюутны универсиад III их наадмын баруун бүсийн тэмцээнд шатрын төрлөөр 5 тамирчин оролцож 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртэн багийн дүнгээр 1-р байр, волейболын төрлөөр 16 тамирчин оролцон мөнгөн медаль хүртэж, багийн дүнгээр 2-р байр эзэлжээ. Ахмадын жү-до бөхийн улсын аваргын тэмцээнд 1 тамирчин оролцож хүрэл медаль, насанд хүрэгчдийн улсын аваргын таеквондогийн тэмцээнд 4 тамирчин оролцож 1 алтан медаль авчирлаа. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн нийт 9 төрлөөр зохион байгуулагдаж 1502 тамирчин оролцлоо. Мөн насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн сагсан бөмбөг, ширээний теннис, шагайн харваа

төрлүүдээр зохион байгуулагдаж 157 тамирчин оролцжээ. Нийтийн биеийн тамирын арга хэмжээний хүрээнд нийт 15 тэмцээн зохиогдож 1900 хүн хамрагдсан байна.

**Стандарчилал, хэмжил зүйн төв:** Тус хэлтсийн хэмжүүрийн лаборатори хүнд, эзэлхүүн багтаамж, цахилгаан, нягт, даралтын хэмжлийн төрлөөр үйлдвэрлэл, үйлчилгээ, эмчилгээ, худалдаа эрхлэгч 70 аж ахуйн нэгж, иргэний 508 ширхэг хэмжүүр, хэмжих хэрэгслийг улсын шалгалт баталгаажуулалтанд хамруулсан байна. 5 нэрийн 8 ширхэг савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хяналт, шалгалт хийж гарсан зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгчээ.

Тус хэлтсийн Баталгаажуулалтын алба Засгийн газрын 2005 оны 127-р тогтоолоор батлагдсан “Чанарын баталгаажуулалтанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтанд орсон 14 бүтээгдэхүүн, 147 ажил үйлчилгээнд тохирлын үнэлгээ явуулж, чанар стандартын шаардлага хангасан 11 үйлчилгээ, 4 бүтээгдэхүүнд “Тохирлын гэрчилгээ” олгожээ.

СХЗГ-н стандарт, мэдээлэл лавлагааны төвөөс шинээр батлагдсан болон шинэчилсэн стандартыг цахим хэлбэрээр захиалан авч 33 аж ахуй нэгж, 5 иргэнд 65 стандартаар үйлчилсэн байна.

**Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар:** Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд 18 сум, 2 тосгонд 473 иргэнд шинэ нэгж талбарт 33.32 га газрыг, 141 иргэнд эзэмшиж, ашиглаж байгаа хашааны газарт 9.98 га газрыг нийт 614 иргэнд 43.30 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэхээр, иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан шинээр 11 суманд 255 өрхөд 6.5 га газрыг эзэмшүүлэхээр, гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн нэгж, байгууллагад төмс, хүнсний ногоо, таримал мод, ургамал тариалах зориулалтаар 11 сум 2 тосгонд 82 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 70.34 га газрыг эзэмшүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

2013 оны эхний улиралд 36 иргэнд 27.5 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд зориулан үнэгүй өмчлүүлсэн байна. Мөн гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газраа өмчилж авсан 6 өрхийн гэр бүлийн хэлцлийг үндэслэн 15 иргэний шинээр газар өмчилж авах эрхийг үүсгэжээ.

**Аймгийн Орон нутгийн өмчийн алба:** 2013 оны 1-р улирлын байдлаар 1 барилга, 3 автомашин хувьчилж 15.0 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ёстой байснаас 1 барилга, 2 орон сууц, 2 автомашин хувьчлаж орон нутгийн төсөвт нийт 43.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

**Тэгш-Алтай:** Авто машины жолоочийн дамжаагаар 36 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүлсэн байна.

**Батлан Хамгаалахад туслах Нийгэмлэг:** Авто машины жолоочийн дамжаагаар 20 хүнийг “В” ангиллаар жолооч мэргэжилтэй болгов.

**Ихэс-Алтай:** Авто машины жолоочийн дамжаагаар 26 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

**Авто тээвэр:** Зорчигч, ачаа тээвэрээр байгууллага иргэдэд үйлчилж 141.9 сая төгрөгийн орлоготой ажиллав.

**Нефть хангамжийн бааз:** Энэ улиралд 700.5 сая төгрөгийн шатахуун тосолгооны материалыг борлуулжээ.

**Эм хангамж ХХК:** Жилийн эхнээс өссөн дүнгээр 60.8 сая төгрөгийн орлоготой, 9 ажиллагчидтай үйл ажиллагаагаа явуулж байна.

**Цахилгаан холбоо компани:** Холбоо ашиглалтын орлого 45.4 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 23.5 сая төгрөг байна. Суурин телефон цэгийн тоо 0.7 мянга,

интернетийн үйлчилгээний 1 цэг 19-н суудалтай ажиллаж интернетээр 1.9 мянган хүнд үйлчилж, интернет байнга хэрэглэгч 750 болжээ.

**Мобиком корпорацийн Говь-Алтай дахь салбар:** Тус салбар дараа төлбөрт хэрэглэгч 0.9 мянга, мобикарт эзэмшигч 27.7 мянга, бүгд 28.6 мянган хэрэглэгчдэд үүрэн телефоноор үйлчилгээ үзүүлж байна.

**Жи-Мобайл ХХК-ний Говь-Алтай дахь салбар:** Тус салбар нь үндсэн хэрэглэгч 0.9 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 18.4 мянга, бүгд 19.3 мянган хэрэглэгчтэй байна.

**Юнител ХХК-ний Говь-Алтай дахь салбар:** Тус салбар нь үндсэн хэрэглэгч 0.2 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 13.3 мянга, бүгд 13.5 мянган хэрэглэгчтэй байна.

**Олон нийтийн Алтай радио:** Энэ улиралд нийт 40 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн цацаж 500.0 мянган төгрөгийн орлого олжээ.

**Шуудан холбооны газар:** Сум, хот, хооронд шуудан, хэвлэл захиалга, зорчигч тээврээр үйлчилж бүгд 17.7 сая төгрөгийн орлоготой ажиллав.

**Зэрэглээт-Алтай кабелийн телевиз:** Кабелийн сувгаар 401 хэрэглэгчдэд үйлчилж, 0.7 сая төгрөгийн орлоготой ажиллав.

**Онцгой байдлын хэлтэс:** Нийт 8 гал түймэр гарч, 4.6 мянган айл өрх, 88 объектод урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, 94.5 сая төгрөгийн хөрөнгийг гал түймрээс аврав. Хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалж гал түймрийн улмаас 10.9 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирлаа.

Энэ улиралд 22 удаагийн гамшгийн дуудлага хүлээн авч 8 удаагийн дуудлага дээр 32 албан хаагч 37.3 цаг ажиллан 213 хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг байгалийн аюулт үзэгдлээс авран хамгаалсан байна.

**Гэмт хэрэг:** Энэ улиралд байгууллага иргэдийн 7.5 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулсан, 50 гэмт хэрэг гарав. Өмнөх оноос гарсан хэрэг 17-оор буюу 25.4 хувиар буурчээ. Гарсан нийт гэмт хэргийн 62.0 хувийг Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна. Дээрэм, булаалт, танхай, БХЖЭсрэг гэмт хэрэг, ТХХАБАЖЭ гэмт хэрэг, залилан, албан газар, орон байр, малаас бусад хулгайн хэрэг 1-ээс 3 дахин нэмэгджээ. Нийт хэргийн улмаас гарсан хохирлын 80.4 хувийг нөхөн төлүүлсэн байна. Эрүүлжүүлэгдсэн хүний тоо өмнөх онтой харьцуулахад 22-оор буюу 6.8 хувиар өсч, гэмт хэрэгт холбогдогчдын тоо 34-өөр буюу 39.1 хувиар, үүнээс гэмт хэрэгт холбогдсон ажилгүй иргэдийн тоо 15-аар буюу 35.8 хувиар тус тус буурч, баривчлагдсан хүний тоо 9-өөр буюу 24.3 хувиар нэмэгджээ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба:** Энэ улиралд 141 гүйцэтгэх хуудасны 1 тэрбум 454.7 сая төгрөгийн төлбөр биелүүлбэл зохихоос 16 гүйцэтгэх хуудасны 22.4 сая төгрөгийн төлбөрийг бодитойгоор биелүүлсэн байна. Хүүхдийн тэтгэвэр 131 гүйцэтгэх хуудасны 29.0 сая төгрөгийн төлбөр биелүүлбэл зохихоос 3 гүйцэтгэх хуудасны 4.0 сая төгрөгийн төлбөрийг бодитойгоор гаргуулсан ба бодит биелэлт 1.5 хувьтай байна.

**ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ**

5/7/2013

	Төллөсөн хээлтэгч						гарсан төл					
	Бүгд	ингэ	гүү	үнээ	эм хонь	эм ямаа	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ишиг
1.Алтай	12841	55	3	5	2417	10361	12841	55	3	5	2417	10361
2.Баян-Уул	12978	15	6	31	7789	5137	12978	15	6	31	7789	5137
3.Бигэр	7135	87	1	30	3683	3334	7135	87	1	30	3683	3334
4.Бугат	15088	21	54	26	4961	10026	15088	21	54	26	4961	10026
5.Дарив	8210	61	23	68	3673	4385	8238	61	23	68	3688	4398
6.Дэлгэр	35267	24	12	36	18320	16875	35267	24	12	36	18320	16875
7.Жаргалан	7667	11	2	27	3257	4370	7801	11	2	27	3310	4451
8.Тайшир	10363	26	0	6	4181	6150	10367	26	0	6	4185	6150
9.Тонхил	13586	0	0	24	6200	7362	13586	0	0	24	6200	7362
10.Төгрөг	16587	427	2	1	7088	9069	16587	427	2	1	7088	9069
11.Халиун	15218	247	4	276	5134	9557	15218	247	4	276	5134	9557
12.Хөхморьт	16764	0	0	8	7373	9383	16764	0	0	8	7373	9383
13.Цогт	23466	229	133	291	13267	9546	23466	229	133	291	13267	9546
14.Цээл	16814	31	8	15	3915	12845	16814	31	8	15	3915	12845
15.Чандмань	13763	0	0	3	6671	7089	13763	0	0	3	6671	7089
16.Шарга	8946	342	25	114	2935	5530	8946	342	25	114	2935	5530
17.Эрдэнэ	26429	20	36	28	4150	22195	26429	20	36	28	4150	22195
18.Есөнбулаг	13472	45	41	63	4263	9060	13472	45	41	63	4263	9060
ДҮН	274594	1641	350	1052	109277	162274	274594	1641	350	1052	109277	162274
2/28/2012	11971	1	5	28	7343	4594	11971	1	5	28	7343	4594

	хорогдсон төл						Бойжсон төл					
	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ишиг	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ишиг
1.Алтай	44	5	3	0	15	21	12797	50	0	5	2402	10340
2.Баян-Уул	77	0	0	0	47	30	12901	15	6	31	7742	5107
3.Бигэр	87	1	0	0	42	44	7048	86	1	30	3641	3290
4.Бугат	850	0	0	0	340	510	14238	21	54	26	4621	9516
5.Дарив	53	0	0	2	27	24	8185	61	23	66	3661	4374
6.Дэлгэр	152	0	0	1	31	120	35115	24	12	35	18289	16755
7.Жаргалан	33	0	0	0	11	22	7768	11	2	27	3299	4429
8.Тайшир	44	0	0	0	14	30	10323	26	0	6	4171	6120
9.Тонхил	120	0	0	0	49	71	13466	0	0	24	6151	7291
10.Төгрөг	8	4	0	0	4	0	16579	423	2	1	7084	9069
11.Халиун	424	1	0	2	149	272	14794	246	4	274	4985	9285
12.Хөхморьт	0	0	0	0	0	0	16764	0	0	8	7373	9383
13.Цогт	200	0	0	0	50	150	23266	229	133	291	13217	9396
14.Цээл	85	0	0	1	26	58	16729	31	8	14	3889	12787
15.Чандмань	0	0	0	0	0	0	13763	0	0	3	6671	7089
16.Шарга	0	0	0	0	0	0	8946	342	25	114	2935	5530
17.Эрдэнэ	399	1	1	2	200	195	26030	19	35	26	3950	22000
18.Есөнбулаг	93	0	0	0	47	46	13379	45	41	63	4216	9014
ДҮН	2669	12	4	8	1052	1593	271925	1629	346	1044	108225	160681
2/28/2012	543	0	0	0	213	330	10966	34	0	1	5161	5770

## ТОМ МАЛЫН ЗҮЙ БУСЫН ХОРОГДЛЫН МЭДЭЭ

	эзлэх хувь	Бүгд хорогдол						Бүгдээс өвчнөөр хорогдсон					Бүгдээс хорогдсон хээлтэгч						
		Бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	Бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	Бүгд	ингэ	гүү	үнээ	эм хонь	эм ямаа
1.Алтай	0.36	190	9	13	6	69	93	0						41	2	8	1	11	19
2.Баян-Уул	0.62	850	7	50	10	126	657	83	4	1	4	9	65	104		2	3	29	70
3.Бигэр	0.25	263	2	16	8	104	133	10	1	1		4	4	102		3	4	43	52
4.Бугат	1.05	794	10	12	13	102	657	0						176		5	2	30	139
5.Дарив	0.24	274	14	15		90	155	0						3					3
6.Дэлгэр	0.58	882			3	148	731	104			2	48	54	149			2	49	98
7.Жаргалан	2.22	1816	4		4	1357	451	14	3		4	3	4	234	2		3	147	82
8.Тайшир	0.11	62		4		6	52	0						2		2			
9.Тонхил	3.32	4422		21	16	813	3572	40				10	30	358				68	290
10.Төгрөг	0.11	106	3	3	7	8	85	44					44	6	3			1	2
11.Халиун	0.88	1210	3	79	31	297	800	57	2		2	21	32	245		16	9	61	159
12.Хөхморьт	0.75	550				35	515	0						0					
13.Цогт	0.29	515		4	7	184	320	0						183				60	123
14.Цээл	0.14	155	4	5	7	34	105	24		1		6	17	69	1	3	1	25	39
15.Чандмань	0.24	251	2			24	225	0						8				6	2
16.Шарга	0.56	518	5	15	10	137	351	7	4		2		1	106	2	5	5	41	53
17.Эрдэнэ	0.28	350		1	2	161	186	0						55				15	40
18.Есөнбулаг	3.16	2842	3	17	11	625	2186	51	3	6	4	15	23	805		6	2	125	672
ДҮН	0.84	16050	66	255	135	4320	11274	434	17	9	18	116	274	2646	10	50	32	711	1843
3/31/2012	1.05	16864	33	142	88	4250	12351	202	1	2	2	62	135	3411	7	31	24	1002	2347

**ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ/мянган төгрөг/**

А		Б	В	Алтай	Баян-Уул	Бигэр	Бугат	Дарив	Дэлгэр	Жаргалан	Тайшир	Тонхил	Төгрөг	Халиун	Хөхморьт	Цогт	Цээл	Чандмана	Шарга	Эрдэнэ	Есөнбулаг
Буур		1	тол	1100	700	1200	1100	1000	1200	1000	1500	900	1100	1200	1000	1000	1200	1000	1200	800	950
Нас гүйцсэн	Нас гүйцсэн ат	2	тол	1000	900	1200	1000	1000	1200	1100	1600	900	1000	1000	1000	1000	1100	1000	1000	800	1000
	Нас гүйцсэн ингэ	3	тол	900	800	900	800	800	900	1000	900	700	900	900	900	800	900	900	900	900	700
Өсвөр	Эр шилбэ	4	тол	600	600	500	500	700	600	450	800	500	800	650	600	500	750	700	500	500	450
	Эм шилбэ	5	тол	600	600	500	500	700	500	450	800	500	800	650	550	500	700	550	500	500	450
Төл	Эр ботго	6	тол	250	150	250	150	250	300	250	300	200	350	300	300	250	250	300	200	200	150
	Эм ботго	7	тол	250	150	250	150	250	300	250	300	200	350	300	300	250	250	300	200	200	150
<b>1.2 Адуу</b>																					
Азарга		8	тол	1000	500	1200	1000	900	800	650	1000	700	700	1000	700	650	1200	550	800	800	1000
Нас гүйцсэн	Соёолон үрээ	9	тол	800	700	800	700	800	750	650	800	700	600	800	700	600	1000	480	600	700	750
	Соёолон гүү	10	тол	650	600	600	550	500	700	650	700	600	500	650	600	600	700	400	500	500	450
Өсвөр	Шүдлэн үрээ	11	тол	450	450	450	450	400	450	450	600	500	400	500	350	300	600	350	300	450	550
	Шүдлэн байдас	12	тол	350	450	450	450	350	400	450	600	500	400	500	350	300	500	350	300	400	500
Төл	Эр унага	13	тол	180	200	300	150	160	200	200	300	150	300	300	200	200	250	200	200	200	100
	Эм унага	14	тол	150	200	300	150	160	200	200	300	150	300	300	200	200	250	200	200	200	100
<b>1.3 Үхэр</b>																					
Бух		15	тол	800	750	1200	1000	1000	1000	850	1000	800	1000	1000	1000	900	1000	850	1000	900	900
Нас гүйцсэн	Хязаалан шар	16	тол	800	800	1150	1000	950	1100	1000	1000	800	1000	1000	1000	850	1100	750	1000	800	1200
	Хязаалан дөнж	17	тол	600	700	800	700	800	800	900	1000	600	800	900	750	750	1000	500	750	750	950
Өсвөр	Шүдлэн эр үхэр	18	тол	550	500	500	550	700	450	700	700	500	750	700	600	800	450	600	700	750	
	Шүдлэн гунж	19	тол	450	500	450	550	500	450	650	600	500	600	600	700	600	700	450	600	600	550
Төл	Эр тугал	20	тол	200	130	250	200	200	200	200	300	100	300	250	200	250	200	200	200	200	150
	Эм тугал	21	тол	200	130	250	200	200	200	200	300	100	300	250	200	250	200	200	200	200	150
<b>1.4 Хонь</b>																					
Хуц		22	тол	150	150	180	180	150	160	150	200	150	150	180	150	150	200	170	160	140	200
Нас гүйцсэн	Эр хонь	23	тол	150	150	150	150	130	160	160	180	150	150	180	150	150	180	150	150	150	180
	Эм хонь	24	тол	120	120	100	100	100	110	120	150	100	100	130	100	100	120	100	110	100	140
Өсвөр	Эр төлөг	25	тол	100	100	80	70	80	90	80	130	70	80	100	70	70	90	80	80	100	120
	Эм төлөг	26	тол	100	100	80	70	80	90	80	130	70	80	100	70	70	70	80	70	80	120
Төл	Эр хурга	27	тол	45	35	40	45	35	45	40	50	40	30	40	40	30	45	50	40	40	50
	Эм хурга	28	тол	45	35	40	45	35	45	40	50	40	30	40	40	30	45	50	40	40	50
<b>1.5 Ямаа</b>																					
Ухна		29	тол	130	120	100	140	110	100	100	150	100	100	150	100	90	120	150	130	110	150
Нас гүйцсэн	Эр ямаа	30	тол	110	100	100	100	90	100	80	140	90	100	120	90	80	120	100	100	100	80
	Эм ямаа	31	тол	85	70	70	70	70	80	70	80	60	80	80	70	80	80	80	70	90	70
Өсвөр	Эр борлон	32	тол	55	45	50	50	50	40	50	70	40	55	60	40	40	80	45	50	50	45
	Эм борлон	33	тол	50	45	50	50	50	40	50	70	30	55	50	40	40	70	45	50	50	45
Төл	Эр ишиг	34	тол	30	20	30	30	25	25	25	40	20	25	20	30	30	40	25	20	35	25
	Эм ишиг	35	тол	30	20	30	30	25	25	25	40	20	25	20	30	30	40	25	20	35	25

Гол нэрийн барааны үнийн мэдээ

2013.04.04

	Алтай	Баян-Уул	Бигэр	Бугат	Дарив	Дэлгэр	Жаргалан	Тайшир	Тонхил	Төгрөг	Халиун	Хөхморьт	Цогт	Цээл	Чандмань	Шарга	Эрдэнэ	Есөнбулаг
Гурил \А.Т-1\, 1кг	780	800	760	880	1000	760	920	850	820	800	800	760	880	850	915	800	800	900
Гурил \Орос\, 1кг	780	820	760	740	800	0	900	0	650	700	700	700	800	800	750	720	800	760
Жигнэмэг,/Янзагатай/ дотоод	350	300	300	300	300	350	300	300	350	350	300	300	300	250	330	300	300	250
Цагаан будаа,/Сайн чанарын/ 1кг	1600	1800	1800	1800	1800	1800	1800	1800	1600	1900	1600	1600	1800	2000	1800	1500	1800	1700
Шар будаа,1кг	2300	1800	1800	1600	1800	1800	2000	1650	1800	1900	1600	1800	2000	2100	1700	2000	2000	1600
Элсэн чихэр,1кг	2000	2000	2000	1800	1800	2000	1800	1800	1800	2000	1600	1700	2000	1800	2000	2000	2000	1700
Чихэр, /Барбарис/ 1 кг	4500	4500	5000	4500	4000	4500	4500	4500	4500	6000	4500	5000	5000	4500	4500	4500	4500	3800
Ногоон цай \ Мөнгөн аягатай\	4500	6000	6000	5500	5500	5000	5000	4600	5000	4500	5000	6000	4500	5500	5400	5000	5500	5000
Давс \ иоджуулсан\ 1 кг	700	800	800	800	650	700	1000	700	650	600	600	1000	1000	1000	650	800	1000	600
Ургамлын тос, л/Санни/	3500	3500	3300	3500	3600	3200	3500	3500	3500	3300	3500	3400	3500	3000	3550	3200	4500	3200
Архи, дотоод, 0.5 л /Ерөөл/	7500	7000	7500	7000	6800	7000	7000	6500	7000	7000	7000	7000	7500	7000	6500	6500	7000	5500
Дүнсэн тамхи \Орос\	6000	6000	6500	5000	6500	5000	6000	6000	6000	4500	6000	6500	6000	5500	6400	6000	6000	5500
Шүдэнз \орос\	500	500	500	500	400	500	500	500	500	600	500	500	600	500	500	500	500	400
Марль 1кг	1000	1000	1000	1000	700	700	800	600	1000	800	1000	1000	1500	1200	800	1000	1000	1000
Эдийн саван /ОК/	600	600	600	600	600	600	600	500	500	600	600	600	600	650	550	600	600	500
Угаалгын нунтаг\ОМО\400 гр ууттай	2500	2800	2000	2500	3200	4000	2500	2000	2500	3000	4200	2500	3000	3500	2500	2000	3000	1800
Цоохор даавуу \Хямд\ 150 см өргөнтэй	4500	3000	3500	2000	3500	0	0	0	1800	2500	2800	3000	2000	1800	1200	2800	0	1800
Лаа \Хятад\	300	300	850	500	300	350	500	350	450	300	400	350	300	350	540	300	300	250
Нүүр гарын саван \LUX\	700	600	650	750	700	800	700	700	600	600	800	800	600	750	750	700	800	500
Шүдний оо, ш, \PS\ 130 гр том	1200	1200	1200	1500	1300	1300	1600	1400	1500	1800	1500	1300	1500	1600	1700	1000	1200	1300
Радионы зай \Хятад\, 1ш	500	500	500	500	500	500	600	500	500	600	600	500	400	550	500	500	500	300
Янжуур \ Улаан шонхор\	1300	1300	1300	1300	1300	1300	1300	1300	1300	1800	1300	1300	1300	1300	1360	1200	1300	1200
Бинзен, 1л	1880	1750	1870	1700	1680	1750	1800	1760	1750	1800	1800	1720	1900	1750	1850	1720	1750	1720
Сумаас аймаг орох нэг талын зардал	30000	10000	20000	17000	15000	6000	12000	4000	17500	14000	10000	17000	25000	25000	20000	7000	20000	0
Цахилгаан задгай, КВ	120	90	90	120	90	88	88	88	88	88	90	88	88	120	90	79.8	79.8	79.8

## Орон нутгийн төсвийн зарлага өссөн дүнгээр

2013.04.04

/мян.төг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>Нийт зарлагын дүн</b>	<b>11712797.7</b>	<b>8879005.8</b>	<b>75.8</b>
<b>Урсгал зардлын дүн</b>	<b>11712797.7</b>	<b>8879005.8</b>	<b>75.8</b>
<b>1.Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>10511181.6</b>	<b>8182158.2</b>	<b>77.8</b>
<b>1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>5316450.6</b>	<b>4738396.8</b>	<b>89.1</b>
Үндсэн цалин	4487240.1	4147758.1	92.4
Нэмэгдэл цалин	60092.3	39351.4	65.5
Гэрээт ажлын цалин	457304.8	376012.9	82.2
Үр дүнгийн урамшуулал	296557.4	161681.2	54.5
Унаа, хоолны хөнгөлөлт	15256.0	13593.2	89.1
<b>1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>580301.0</b>	<b>507124.2</b>	<b>87.4</b>
Тэтгэвэр тэтгэмжийн даатгалын шимтгэл	475184.3	430758.7	90.7
Байгууллагаас төлөх ЭМД-н шимтгэл	105116.7	76365.5	72.6
<b>1.3 Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4614430.0</b>	<b>2936637.2</b>	<b>63.6</b>
<b>Татаас ба урсгал шилжүүлэг</b>	<b>1201616.1</b>	<b>696847.6</b>	<b>58.0</b>
Өрх гэрт олгох шилжүүлэг	982325.8	588593.2	59.9
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	219290.3	108254.4	49.4
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0

## Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээ

/мян.төг/

Сум, байгууллагын нэр	Орон нутаг		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Алтай	403784.7	384398.2	95.2
Баян-Уул	387366.7	285958.6	73.8
Бигэр	316943.2	243030.8	76.7
Бугат	372106.6	189330.8	50.9
Дарив	372349.6	325190.5	87.3
Дэлгэр	582579.1	458943.2	78.8
Жаргалан	265800.2	198114.1	74.5
Тайшир	279964.4	205599.9	73.4
Тонхил	338048.8	272370.3	80.6
Төгрөг	331512.8	261214.7	78.8
Халиун	346571.1	258344.8	74.5
Хөхморьт	400967.0	354272.7	88.4
Цогт	654214.0	526431.5	80.5
Цээл	297974.5	203434.6	68.3
Чандмана	350499.2	282232.6	80.5
Шарга	337831.2	265644.7	78.6
Эрдэнэ	363075.0	320274.2	88.2
Есөнбулаг	2225813.4	1900883.4	85.4
Шууд харилцагч	3085396.2	1943336.2	63.0
<b>Дүн</b>	<b>11712797.7</b>	<b>8879005.8</b>	<b>75.8</b>

**АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ ӨССӨН ДҮНГЭЭР**

2013.04.04

/мян.төг/

ОРЛОГЫН ТӨРӨЛ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь хэмжээ
<b>I. СУМЫН ТӨСВИЙН ОРЛОГО</b>	<b>184665.5</b>	<b>242899.0</b>	<b>131.5</b>
<b>II. Урсгал орлого</b>	<b>170665.5</b>	<b>200407.7</b>	<b>117.4</b>
<b>III. Татварын орлого</b>	<b>82415.9</b>	<b>78517.4</b>	<b>95.3</b>
<b>1. Орлогын албан татвар</b>	<b>36757.9</b>	<b>48740.5</b>	<b>132.6</b>
<b>1.1 Хүн амын орлогын албан татвар</b>	<b>36757.9</b>	<b>48740.5</b>	<b>132.6</b>
Үйл ажиллагааны орлого	16145.1	19186.4	118.8
Хөрөнгө борлуулсны орлого	15200.0	20366.0	134.0
ОТБТБАҮЭИҮАТ	2020.5	901.0	44.6
Мал бүхий иргэдийн орлого	0.0	269.9	0.0
Бусад орлого	3392.3	8017.2	236.3
<b>2. Өмчийн татвар</b>	<b>542.3</b>	<b>330.0</b>	<b>60.9</b>
Бууны албан татвар	542.3	330.0	60.9
<b>3. Бусад татвар /төлбөр, хураамж/</b>	<b>45115.7</b>	<b>29446.9</b>	<b>65.3</b>
Улсын тэмдэгтийн хураамж	16520.9	19238.9	116.5
Улсын тэмдэгтийн хураамжийн буцаан олголт	-1000.0	-276.5	27.7
Рашаан, ус ашигласны төлбөр	7779.8	2495.5	32.1
Ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	30.0	341.0	1136.7
Агнуурын нөөц ашигласны төлбөр	0.0	0.0	0.0
ТТАМАТ	675.0	1425.3	211.2
Байгалийн ургамал ашигласны төлбөр	0.0	17.9	0.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	21110.0	6204.8	29.4
<b>IV. Татварын бус орлого</b>	<b>88249.6</b>	<b>121890.3</b>	<b>138.1</b>
хүү, торгуулийн орлого	43768.3	31903.9	72.9
түрээсийн орлого	354.0	333.0	94.1
төсөвт газрын өөрийн орлого	1904.8	5305.2	278.5
нэр заагдаагүй бусад орлого	42222.5	84348.2	199.8
<b>V. Хөрөнгийн орлого</b>	<b>14000.0</b>	<b>42491.3</b>	<b>303.5</b>
өмч хувьчлалын орлого	14000.0	42491.3	303.5
<b>ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ</b>	<b>1051969.3</b>	<b>928566.5</b>	<b>88.3</b>
Цалин ХТА орлогын албан татвар	989829.9	766322.1	77.4
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	0.0	0.0
Үл хөдлөх хөрөнгийн татвар	33914.3	30343.9	89.5
Газрын төлбөр	15750.7	10718.0	68.0
Газрын дуудлага худалдаа	0.0	0.0	0.0
АТБӨЯ хэрэгслийн албан татвар	10224.4	10745.0	105.1
Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	2250.0	1937.5	0.0
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	0.0	108500.0	0.0
<b>Орон нутгийн төсөв /өссөн дүнгээр/</b>	<b>1236634.8</b>	<b>1171465.5</b>	<b>94.7</b>
<b>УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ОРЛОГО</b>	<b>130885.2</b>	<b>190015.2</b>	<b>145.2</b>
ААНБОАлбан татвар	19000.0	71305.4	375.3
Дотоодын бараа үйлчилгээний НӨТ	102000.0	109736.1	107.6
Дотоодын архины онцгой албан татвар	8280.0	3440.9	41.6
Агаарын бохирдолын төлбөр АТБӨЯ	1605.2	5532.8	344.7
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	0.0	0.0	0.0
<b>ТӨСВИЙН ОРЛОГЫН НИЙТ ДҮН</b>	<b>1367520.0</b>	<b>1361480.7</b>	<b>99.6</b>

**АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ сумаар,оны  
үнээр GROSS INDUSTRIAL OUTPUT, by som, at current price**

мян.төг / thous.tug/

Сумд	Som	2012.III	2013.III	Дүнд эзлэх хувь Percentage share to total	
				2012	2013
<b>Нийт дүн</b>	<b>Total</b>	<b>2579065.1</b>	<b>2382591.1</b>	<b>100.00</b>	<b>99.80</b>
Алтай	Altai	2270	6393.5	0.09	0.27
Баян-Уул	Bayan-Uul	2588.3	9721.5	0.10	0.41
Бигэр	Biger	4729.1	21985.8	0.18	0.92
Бугат	Biger	2839.1	6171.1	0.11	0.26
Дарив	Darib	27443.7	91186.1	1.06	3.83
Дэлгэр	Delger	3965.1	14709.6	0.15	0.62
Жаргалан	Jargalan	3921.5	8977.0	0.15	0.38
Тайшир	Taishir	16557.5	47331.6	0.64	1.99
Тонхил	Tonhil	1922.0	7041.9	0.07	0.30
Төгрөг	Tugrug	1806.2	8311.6	0.07	0.35
Халиун	Haliun	1545.4	4659.6	0.06	0.20
Хөхморьт	Huhmorit	3433.9	5853.4	0.13	0.25
Цогт	Tsogt	3165.1	8528.4	0.12	0.36
Цээл	Tseel	1509.0	6851.5	0.06	0.29
Чандмань	Chandmana	44893.5	64952.4	1.74	2.73
Шарга	Sharga	1193.3	6244.9	0.05	0.26
Эрдэнэ	Erdene	18092.6	52879.3	0.70	2.22
Есөнбулаг	Yesunbulag	2437189.8	2005994.7	94.5	84.2
Шилүүстэй	Shiluustei	1276.9	4797.2	0.0	0.2

**АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, оны үнээр**  
**GROSS INDUSTRIAL OUTPUT, at division, at current prices**

мян.төг thous tog

Аж үйлдвэрийн салбар		2012.III	2013.III	2012.I-III	2013.I-III	Дүнд эзлэх хувь Percentage share to total		
						2011	2012	
<b>Нийт дүн</b>		<b>1225173.4</b>	<b>1126308.6</b>	<b>4109891.3</b>	<b>3540461.6</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>	
Уул уурхай, олборлох аж үйлдвэр		100042.5	85680.7	275205.3	275220.6	6.70	7.77	
Үүнээс	Нүүрс олборлолт	100042.5	85680.7	275205.3	275220.6	6.70	7.77	
Боловсруулах үйлдвэр		54267.4	51229.2	187756.7	182948.3	4.57	5.17	
Үүнээс	Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	42969.4	38125.2	147948.2	140000.7	3.60	3.95	
	Үүнээс	Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.0	0.0	0	0	0.00	0.00
		Үр тарианы гурил үйлдвэрлэл	0.0	0.0	0	0	0.00	0.00
		Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	28406.1	20399.7	98122.26	67240.9	2.39	1.90
		Ундаа үйлдвэрлэл/согтууруулах ундаа ороод/	14563.3	17725.5	49825.9	72759.8	1.21	2.06
	Нэхмэлийн үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	0.0	0.00	0.00	
	Хувцас үйлдвэрлэл	1440	3500	5520	18130	0.13	0.51	
	Арьс шир боловсруулах, гутал үйлдвэрлэл	6385	1190	27488.5	12019.6	0.67	0.34	
	Модон эдлэл үйлдвэрлэл	3067	342	5582	1672	0.14	0.05	
	Төмөр бетонон эдлэл	0.0	8000.0	0.0	8000.0	0.00	0.23	
	Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	0.0	0.0	0.0	0.0	0.00	0.00	
	Төмрийн үйлдвэрлэл	96	72	288	216	0.01	0.01	
	Мебель тавилга үйлдвэрлэл	310.0	0.0	930.0	2500.0	0.02	0.07	
Бусад үйлдвэрлэл	0	0	0	410	0.00	0.01		
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж		1070863.5	989398.7	3646929.4	3082292.7	88.74	87.06	
Үүнээс	Цахилгаан үйлдвэрлэл	551280	477422	2110173	1531816	51.34	43.27	
	Дулаан үйлдвэрлэл	482178.6	471108.8	1419132.3	1417427.1	34.53	40.04	
	Ус ариутгал, усан хангамж	37404.9	40867.9	117624.06	133049.6	2.86	3.76	

**АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН сумаар,оны үнээр GROSS  
INDUSTRIAL OUTPUT, by som, at current price**

мян.төг / thous.tug/

Сумд	Som	2012.III	2013.III	Дүнд эзлэх хувь Percentage share to total	
				2012	2013
<b>Нийт дүн</b>	<b>Total</b>	<b>4109891.3</b>	<b>3540461.6</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>
Алтай	Altai	9743.67333	11467.0	0.24	0.32
Баян-Уул	Bayan-Uul	43823.7631	2682.6	1.07	0.08
Бигэр	Biger	26265.8757	11147.6	0.64	0.31
Бугат	Bugat	10096.7	9178.8	0.25	0.26
Дарив	Darib	103472.97	85981.4	2.52	2.43
Дэлгэр	Delger	11230.2	13271.7	0.27	0.37
Жаргалан	Jargalan	9522.5289	2677.8	0.23	0.08
Тайшир	Taishir	44941.0752	44592.5	1.09	1.26
Тонхил	Tonhil	23065.6	6774.5	0.56	0.19
Төгрөг	Tugrug	7565.82788	4067.6	0.18	0.11
Халиун	Haliun	17786.4231	2644.6	0.43	0.07
Хөхморьт	Huhmorit	29670.927	10482.5	0.72	0.30
Цогт	Tsogt	30489.54	4451.4	0.74	0.13
Цээл	Tseel	8308.0	7411.8	0.20	0.21
Чандмань	Chandmani	102807.545	57101.9	2.50	1.61
Шарга	Sharga	10189.9776	2915.4	0.25	0.08
Эрдэнэ	Erdene	61116.7862	52070.4	1.49	1.47
Есөнбулаг	Yesunbulag	3559793.83	3210191.62	86.62	90.67
Шилүүстэй	Shiluustei	757.929333	1350.4	0.0	0.04

**АЖ ҮЙЛДВЭР**  
**/ INDUSTRY/**  
**АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, оны үнээр**  
**SOLD PRODUCTION OF INDUSTRY, at division, at current prices**

мян.төг thous tog

Аж үйлдвэрийн салбар		2012.III	2013.III	2012.I-III	2013.I-III	Дүнд эзлэх хувь Percentage share to total			
						2012	2013		
<b>Нийт дүн</b>		<b>931626.5</b>	<b>781523.3</b>	<b>2579065.1</b>	<b>2382591.1</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>		
Уул уурхай, олборлох аж үйлдвэр		105725	97242.5	295435	304967.4	11.46	12.80		
Үүнээс	Нүүрс олборлолт	105725	97242.5	295435	304967.4	11.46	12.80		
Боловсруулах аж үйлдвэр		65845.0	50566.1	216634.4	218729.3	8.40	9.18		
Үүнээс	Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт		51480.0	35444.1	177734.4	170500.3	6.89	7.16	
	Үүнээс	Үүнээс	Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0	0	0	0	0.00	0.00
			Үр тарианы гурил үйлдвэрлэл	0.0	0.0	177734.4	0	6.89	0.00
			Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	31590	23278.1	107034.4	86559.3	4.15	3.63
			Ундаа үйлдвэрлэл/согтууруулах ундаа ороод/	19890	12166	70700	83941	2.74	3.52
	Нэхмэлийн үйлдвэрлэл		0.0	0.0	0.0	0.0	0.00	0.00	
	Хувцас үйлдвэрлэл		1700	4020	6580	23320	0.26	0.98	
	Арьс шир боловсруулах, гутал үйлдвэрлэл		8305	1780	23005	11033	0.89	0.46	
	Модон эдлэл үйлдвэрлэл		3870	440	7685	1260	0.30	0.05	
	Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл		0.0	0.0	0.0	0.0	0.00	0.00	
	Төмөр бетонон эдлэл		0.0	8800.0	0.0	8800.0	0.00	0.37	
	Төмрийн үйлдвэрлэл		110	82	330	246	0.01	0.01	
	Мебель тавилга үйлдвэрлэл		380.0	0.0	1300.0	2750.0	0.05	0.12	
Бусад үйлдвэрлэл		0	0	0	820	0.00	0.03		
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж		760056.5	633714.7	2066995.7	1858894.4	80.15	78.02		
Үүнээс	Цахилгаан үйлдвэрлэл		179132.6	233006.5	639297.5	653481.7	24.79	27.43	
	Дулаан үйлдвэрлэл		543519.0	359840.3	1310074.1	1072363	50.80	45.01	
	Ус ариутгал, усан хангамж		37404.9	40867.9	117624.06	133049.69	4.56	5.58	

**ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ PRODUCTION OF MAJOR  
COMMODITIES**

<b>Гол нэрийн бүтээгдэхүүн</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>2012.III</b>	<b>2012.I-III</b>	<b>2013.III</b>	<b>2013.I-III</b>	<b>2012.I- III% 2013- I-III</b>
Цахилгаан эрчим хүч	мян.квт.цаг	2756.4	9286	2170.1	6962.8	75.0
Дулааны эрчим хүч	мян. Гкал	21.12	62.2	20.4	61.4	98.7
Түгээсэн цэвэр ус	мян. м3	9.3	31.14	10.7	35.5	114.0
Нүүрс	мян.тн	4.07	11.6	3.6	11.7	100.9
Эсгий	мян.м	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гутал, ботинк	хос	201	902	42	351	38.9
Монгол дээл	ширхэг	26	108	67	393	363.9
Хиам	тн	1.2	4.1	0.8	2.4	58.5
Архи, дарс	мян.л	4.1	14.82	3.7	19.87	134.1
Амтат ус, ундаа	мян.л	1.03	2.06	0	1.55	75.2
Талх	тн	5.088	12.82	1.7	7.2	56.2
Нарийн боов	тн	10.42	33.54	8.13	20.49	61.1
Зайрмаг	мян.ш	0.01	0.03	0.4	1.2	4000.0
Сувагжуулалт	мян.м3	8.4	23.8	7.8	25.1	105.5

## ХӨДӨЛМӨР

### LABOUR

7.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны эцэст

NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of period

Боловсролын түвшингээр	By educational level	2009.XII	2010.XII	2011.XII	2012.XII	3-cap In March	
						2012	2013
<b>Бүгд</b>	<b>Total</b>	<b>996</b>	<b>817</b>	<b>821</b>	<b>840</b>	<b>734</b>	<b>790</b>
Үүнээс: эмэгтэй	of which:female	686	516	519	540	425	498
Дээд боловсролтой	Higher education	319	235	243	325	168	276
Тусгай дунд боловсролтой	Specialized secondary education	73	69	64	50	65	57
Мэргэжлийн анхан шатны	Professional technical and vocational training workers	66	39	36	53	33	42
Бүрэн дунд	Upper secondary school	367	294	299	246	203	254
Суурь	Compulsory secondary school	147	143	140	106	182	97
Бага	Primary school	19	30	32	43	56	54
Боловсролгүй	Uneducated persons	5	7	7	17	27	10

7.2 АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, насны бүлгээр, 2013 оны 3-р сарын эцэст

NUMBER OF UNEMPLOYED, by age group, at the end of March 2013

Сар Months	Бүгд Total	Үүнээс: эмэгтэй female	Үүнээс:насны бүлгээр of whom:by age group							
			16-24	Эмэгтэй female	25-34	Эмэгтэй female	35-44	Эмэгтэй female	45-59	Эмэгтэй female
II	816	535	171	123	354	234	169	112	122	57
III	790	498	171	111	340	207	167	119	112	61

7.3 2013 ОНЫ 3 САРД АЖИЛД ОРСОН ХҮН

NUMBER OF UNEMPLOYED ENTERED INTO WORK, in the 3 months of 2013

Сар Month	Бүгд Total	Улсын үйлд- вэрийн газарт State enterprise	Төрийн төсөвт байгууллагад Government organization	Компани Company	Хоршоо Co- operative	Бусад Other
II	160			136	8	16
III	22		5	17		

7.4 АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, боловсролын түвшингээр, 2013 оны 3-р сарын эцэст  
NUMBER OF UNEMPLOYED PERSONS, by educational level, at the end of March 2013

Сар Month	Бүгд Total	Дээд боловсролтой Higher education	Тусгай дунд боловсролтой Specialized secondary education	Мэргэжлийн анхан шатны Skilled workers	Бүрэн дунд боловсролтой Completed secondary school	Суурь боловсролтой Non-completed secondary school	Бага боловсролтой Completed primary school	Боловсролгүй Uneducated persons
II	816	348	39	50	227	93	43	16
III	790	276	57	42	254	97	54	10

7.5 АЖИЛГҮЙЧҮҮД, 2013 оны 3 сард ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ХҮН  
NUMBER UNEMPLOYED AND NEWLY REGISTERED PERSONS, in the 3 month of 2013

Сар Month	Ажилгүйчүүдийн тоо, 3-р сарын эцэст Number of unemployed, at the end of 3 months			3-р сард шинээр бүртгүүлсэн ажилгүй хүн Number of unemployed newly registered in the 3 months		
	2012	2013	2013 % 2012	2012	2013	2013 % 2012
II	824	816	99.0	15	133	8.9 дахин
III	734	790	107.6	36	327	9.0 дахин

7.6 АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМДААР  
NUMBER OF UNEMPLOYED, by som

Сум	Sum	Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed						
		2009.XII	2010.XII	2011.XII	2012.XII	3-р сар in March		
						2012	2013	2013% 2012
Алтай	Altai	39	36	0	10	0	24	-
Баян-Уул	Bayan-Uul	32	27	28	22	28	24	85.7
Бигэр	Biger	20	107	101	54	94	100	106.4
Бугат	Bugat	42	11	51	48	48	49	102.1
Дарив	Darib	54	49	71	39	70	37	52.9
Дэлгэр	Delger	37	33	78	43	77	31	40.3
Жаргалан	Jargalan	13	12	30	15	27	18	66.7
Тайшир	Taishir	12	28	10	2	9	10	111.1
Тонхил	Tonhil	13	25	21	26	21	21	100.0
Төгрөг	Tugrug	15	58	52	40	46	53	115.2

Халиун	Haliun	15	11	24	20	22	23	104.5
Хөхморьт	Huhmorit	13	9	16	16	12	20	166.7
Цогт	Tsogt	39	51	71	61	61	49	80.3
Цээл	Tseel	31	37	71	53	46	27	58.7
Чандмань	Chandmani	48	35	35	35	32	30	93.8
Шарга	Sharga	8	13	24	14	24	21	87.5
Эрдэнэ	Erdene	14	19	15	16	15	16	106.7
Есөнбулаг	Yesunbulag	551	256	114	326	102	237	232.4
<b>ДҮН</b>	<b>TOTAL</b>	<b>996</b>	<b>817</b>	<b>812</b>	<b>840</b>	<b>734</b>	<b>790</b>	<b>107.6</b>



Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлт

2013.04.04

Д/д	Сумын нэр	төрсөн эх		эхийн эндэгдэл		төрсөн хүүхэд		Нялхасын эндэгдэл		1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		Нийт нас баралт		Эмнэлэгт нас баралт		Цочмог халдварт өвчлөл бүгд		Үүнээс:															
																		БЗХӨ						Гепатит		Сүрьеэ		Гахайн хавдар		бусад			
		трихоминаз	тэмбүү	заг хүйтэн	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013	2012	2013															
1	Алтай	3	4			3	4	0	0			2	1	2		0	2				1				1					0	0		
2	Баян-Уул	4	3			3	3	0	0			9	1	3		0	4				1					1			0	2			
3	Бигэр	5	3			5	3	0	1			4	1		1	3	1						2	1					1	0			
4	Бугат	5	5			5	5	0	1				3		2	16	3						16					2	0	1			
5	Гуулин					0		0	0			4	1	1	1	1	1					1	1						0	0			
6	Дарив	11	2			11	2	0	0			4	0	1		1	4					1	2		2				0	0			
7	Дэлгэр	4	3			4	3	0	0			1	4		1	6	1					1		3			2		0	1			
8	Жаргалан					0		0	0				3		1	2	1			2								1	0	0			
9	Тайшир	1	1			1	1	0	0			2	5		1	1	1					1							0	1			
10	Тонхил	6	7			6	7	0	0			7	5	2	3	0	3					3							0	0			
11	Төгрөг	8	4			8	4	2	0			4	1	3		1	0						1						0	0			
12	Халиун		3			0	3	0	0			1	4		1	1	0			1									0	0			
13	Хөхморьт	3	1			2	1	1	0			3	1	2		1	2					1		1					0	0			
14	Цогт	3	5			3	5	0	0			4	2	1	2	0	0												0	0			
15	Цээл	2	4			2	4	0	1			1	5	1	2	6	4			1	3			4		1			0	1			
16	Чандмана	2	4			2	4	0	0			4	3		1	8	1					1	7		1				0	0			
17	Шарга					0		0	1		1	1	3			3	1			2	1			1					0	0			
18	Эрдэнэ	2	4			2	4	0	3			6	5	1	3	0	0												0	0			
19	Баянтоорой	2				2		0	0			6	2	1	1	0	2				2								0	0			
20	Сумын дүн	61	53	0	0	59	53	3	7	0	1	63	50	18	20	50	31	0	0	6	12	4	4	35	5	2	1	2	3	1	6		
21	Есөнбулаг	292	297			294	303	4	5			20	27	7	10	66	38	1		7	12	11	8	38	1	0	2	2	3	7	12		
22	Дүн	353	350	0	0	353	356	7	12	0	1	83	77	25	30	116	69	1	0	13	24	15	12	73	6	2	3	4	6	8	18		

**Холбооны салбарын төлөвлөгөөний биелэлтийн мэдээ**

April 4, 2013

	Өмнөх оны мөн үед	2013 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Нийт орлого	27386.3	40100.0	39750.0	99.1
Үүнээс Хүн амаас	6302	25000.0	23000.0	92.0
Телефон цэгийн тоо	1028	829	829	100.0
Үүнээс Хүн амаас	644	630	620	98.4

**Монгол банкны орлого, зарлага, зээл хадгаламжийн кассын мэдээ**

3 сар

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт		Мөрийн дугаар дугаар	Өмнөх оны мөн үе	Гүйцэтгэл	Хувь
Банкны кассын	Орлого банкинд шилжүүлсэн	1	8868560.0	4312840.0	48.6
	Гүйлгээнээс татсан	2	80401835.3	66440168.7	82.6
	Зарлага банкинд шилжүүлсэн	3	8075788.0	4934166.0	61.1
	Гүйлгээнээс татсан	4	77383932.2	64396779.9	83.2
3.Зээлийн өрийн бүх үлдэгдэл		5	39155103.2	47416089.2	121.1
4.Үүнээс хугацаа хэтэрсэн зээл		6	231408.0	170833.1	73.8
5.Хөдөлмөрчдийн хувийн хадгаламжийн үлдэгдэл		7	28837959.2	35829427.1	124.2
6.Хугацаат хадгаламж		8	18261073.1	21567058.9	118.1